



## ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2017 оны 11 сарын 27 өдөр

Дугаар A/208

Улаанбаатар хот

### Үнэлгээ хийх тухай

Эрүүл мэндийн сайд, Боловсрол соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан 491/A472 тушаалын 3.2.5, 3.2.7 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2016 оны А/203 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 4.7.6, 7.4.2 дахь заалт, тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төгсөлтийн дараах сургалтын бааз, чадамж, орчинг үнэлэх, улсын төсвийн санхүүжилтээр суралцсан эмнэлгийн мэргэжилтний гэрээний хэрэгжилтэд хяналт хийх, үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх судалгааны мэдээлэл цуглуулах ажлын удирдамжийг нэгдүгээр, төсвийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Үнэлгээтэй холбоотой гарах зардлыг Хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах няглан бодогч /Д.Гантуяа/-д зөвшөөрсүгэй.
3. Үнэлгээг удирдамжийн дагуу чанартай зохион байгуулахыг Эрүүл мэндийн ажилтны хөгжлийн алба /З.Наранбаатар/-нд үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүү-үйлчилгээний алба /Л.Оюунчимэг/-нд даалгасугай.

ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.НАРАНТУЯА

Ерөнхий захирлын 2017 оны ... сарын  
... өдрийн ... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



АЙМАГ, ДҮҮРГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ТӨГСӨЛТИЙН ДАРААХ  
СУРГАЛТЫН БААЗ, ЧАДАМЖ, ОРЧИНГ ҮНЭЛЭХ, УЛСЫН ТӨСВИЙН  
САНХУЖИЛТЭЭР СУРАЛЦСАН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ ГЭРЭЭНИЙ  
ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ХИЙХ АЖЛЫНУДИРДАМЖ

## Үндэслэл:

Монгол Улс, Япон Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны гэрээнд тусгагдан хэрэгжиж буй “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хүрээнд Орхон, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийг төгсөлтийн дараах сургалт эрхлэх байгууллага болгон өргөжүүлэх зорилгоор төгсөлтийн дараах сургалт эрхлэгч байгууллагын багшлах хүний нөөцийг чадавхижуулах ажлыг З дахь жилдээ амжилттай зохион байгуулж байна.

Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага болон Эрүүл мэндийн Яамны хамтран хэрэгжүүлж буй “Анхан ба хоёр дахь шатлалын эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах” төслийн хамтарсан зохицуулах зөвлөлийн хурлын баримт бичигт тусгагдсан ажлыг хэрэгжүүлэх зорилгоор Орхон, Дорнод аймгийн Бусийн оношилгоо эмчилгээний төв, Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн төгсөлтийн дараах сургалт явуулах чадамж, бааз, орчинг үнэлэх, улмаар сургалт эрхлэх эрх олгох бэлтгэл ажлыг хангах шаардлагатай байна.

### Зорилго:

Аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлгийн төгсөлтийн дараах сургалтын бааз, чадамж, орчинг үнэлэх, улсын төсвийн санхүүжилтээр суралцсан эмнэлгийн мэргэжилтний гэрээний хэрэгжилтэд хяналт хийх, үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдалд үнэлгээ өгөх судалгааны мэдээлэл цуглуулах, эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулахад оршино.

## Гүйцэтгэх ажил:

1. Орхон, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн төгсөлтийн дараах сургалтын чадамж, орчныг үнэлж, мэргэжилтэй зүйн зөвлөгөө өгөх
  2. Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2017 онд улсын төсвийн санхүүжилтээр хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийх
  3. Үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдлыг үнэлэх судалгааны мэдээлэл цуглуулах
  4. Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалт зохион байгуулах
  5. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх

зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 491/A/472 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугар тушаалаар батлагдсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” журмыг танилцуулах, сурталчлах

**Үнэлгээ хийх бүрэлдэхүүн:**

О.Баярсайхан /ЭМАХА-ны мэргэжилтэн/ ажлын хэсгийн ахлагч  
П.Эрхэмбаяр /ЭМАХА-ны мэргэжилтэн/ гишүүн  
Д.Баярхүү /ЭМАХА-ны мэргэжилтэн/ гишүүн

**Хамрах хүрээ:** Орхон, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг

**Хугацаа:**

2017 оны 11 дүгээр сарын 27-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг дуустал

**Үр дүн:**

1. Орхон, Дорнод аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Булган аймгийн Нэгдсэн эмнэлгийн төгсөлтийн дараах сургалтын бааз, чадамж, орчинд үнэлгээ хийж дүгнэлт гаргаж зөвлөмж хүргүүлж, төгсөлтийн дараах сургалт эрхлэх эрх авах бэлтгэл ажил хангагдсан байна.
2. Төгсөлтийн дараах үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн сургалтад 2012-2017 онд аймгаас улсын төсвийн санхүүжилтээр хамрагдсан эмч, эмнэлгийн мэргэжилтний төрийн сангийн гэрээний хэрэгжилтэд хяналт хийж үр дүнг тооцсон байна.
3. Үндсэн мэргэшлийн сургалтын өнөөгийн байдлыг үнэлэх судалгааны мэдээлэл цуглуулсан байна.
4. Үнэлгээ хийгдэж буй аймгийн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтыг зохион байгуулсан байна.
5. Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны “Журам батлах тухай” 98 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журам”, Эрүүл мэнд, Боловсрол, шинжлэх ухааны сайдын хамтарсан 2013 оны 491/A/472 дугаар тушаалаар батлагдсан “Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах мэргэшүүлэх болон давтан сургалт явуулах, зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох журам”, Монгол улсын эрүүл мэнд, спортын сайд, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 97/56 дугар тушаалаар батлагдсан “Журам батлах, зардлын жишиг, төлбөрийн хэмжээ тогтоох тухай” журмыг танилцуулж сурталчилсан байна.

Ерөнхий захирын  
2017 оны 11 сарын 27 өдрийн 11 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

### АЛБАН ТОМИЛОЛТЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Явах чиглэл:

#### УЛААНБААТАР- ОРХОН-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног /хоол/	16,000	3	2	96,000
2	Зочид буудал	35,000	3	1	105,000
3	Нийтийн тээвэр	24,500	3		147,000
	<b>ДҮН</b>				<b>348,000</b>

Явах чиглэл:

#### УЛААНБААТАР- БУЛГАН-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног	14,000	3	3	126,000
2	Зочид буудал	35,000	3	2	210,000
3	Нийтийн тээвэр	24,500	3		147,000
	<b>ДҮН</b>				<b>483,000</b>

Явах чиглэл:

#### УЛААНБААТАР- ДОРНОД-УЛААНБААТАР

Д/д	Албан тушаал	Тооцох зам хоног	Хүний тоо	Албан томилолтын хугацаа	Нийт зам хоногийн зардал
1	Зам хоног	14,000	3	3	126,000
2	Зочид буудал	35,000	3	2	210,000
	<b>ДҮН</b>				<b>336,000</b>

Шатахууны зардал:

Д/д	Тээврийн хэрэгсэл	100 км-т зарцуулах норм	Явах км /2 талдаа/	1 литр шатахууны үнэ	Нийт замын зардал
1	Автомашин: /Дорнод аймаг болон 2 суманд явах/	15	1580	1,660	393,420
	<b>ДҮН</b>				<b>393,420</b>

#### НИЙТ ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ

1,560,420

Хянасан: Ахлах нягтлан бодогч

Д.Гантуяа

Боловсруулсан: Нягтлан бодогч

С.Лхагвасүрэн